



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2026 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

2022 он

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Геронтологийн үндэсний төв нь Монгол Улсын хэмжээнд настан хүн амд төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх, настны эрүүл мэндийн цогц үнэлгээ хийх, настанд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, өвчлөлөөс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын тусламж, үйлчилгээ, нөтөлгоонд тулгуурласан эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах, настан хүн амын дундах өвчлөл, өвчний тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа эрдэм шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага болно.

Европ тивд ажиглагдаж байсан хүн амын насжилт одоо дэлхий нийтийн асуудал болоод байна. Хүн амын насжилт нэмэгдсэнээр эдийн засаг, гэр бүл, шашин шүтлэг, улс төр, амралт, эрүүл мэнд, ажиллах хүч, боловсрол гэх мэт өргөн хүрээнд үр дагавар авчрах юм. Энэхүү томоохон өөрчлөлт нь дараах гурван шалтгаанаас болж үүсч байна. Үүнд төрөлтийн бууралт, нас баралтын бууралт ба дундаж насжилт нэмэгдсэн, хүн амын шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалж байна.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын дүнд суурилсан “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо” -ны үр дүнд үндэслэн 55 ба түүнээс дээш насны ахмадуудын нийт хүн амд эзлэх хувийг тооцож үзэхэд 2015 онд 5.7 хувийг эзэлж байсан бол 2021 оны байдлаар Монгол Улсад 60 ба түүнээс дээш насны иргэд нийт хүн амын 9.7 хувь байгаа нь 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60, түүнээс дээш насны хүн ам болох магадлалыг гаргасан байна.

Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2021 оны байдлаар 71.7 жил /эрэгтэйчүүд 67.5, эмэгтэйчүүд 76.47/ байна. Эрэгтэй, эмэгтэй настнуудын дундаж насжилтын зөрүү өндөр байгаа нь настны амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, тэд амьдралынхаа тодорхой үеийг ганцаардал, сэтгэл гутрал, айдас түгшил, орлогын хомсдолтой байдалд өнгөрүүлж байна. Насжилттай холбоотой гарах өөрчлөлтүүд мэдрэл, зүрх судас, амьсгалын замын эрхтэн тогтолцоо, тулгуур хөдөлгөөн болон бодисын солилцоонд илүү тод илэрдэг. Ой тогтоомж сулрах, хараа, сонсгол муудах, хайнга, цочромтгой болох, судас хатуурах, амьсгалын багтаамж багасах, хөдөлгөөн удаашрах зэрэг эрхтэн тогтолцооны өөрчлөлтүүд

илүү тод илрэх ба настны хөдөлмөрийн чадвар, бие даах чадвар, багаж хэрэгсэлтэй харьцах чадвар алдагдах үндсэн шалтгаан болж байна.

2011 онд хийсэн “Монгол настуудын өвчлөлийн тархалт нийгэм, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал” судалгаагаар ахмад настуудын 85.2 хувь нь архаг хавсарсан өвчлөлтэй байсан. 2021 оны “Эрүүл насжих хэрэгцээ” судалгаагаар судалгаанд хамрагдсан настуудын 50 хувьд эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай, 56 хувьд асаргаа шаардлагатай байсан.

2018 оны Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаагаар эмнэлгээр үйлчлүүлэгчдийн 24.1 хувь ахмад настан байсан ба тэдгээрийн 35.1 хувь зүрх судасны өвчин, 12.6 хувь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 10.3 хувь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 8.7 хувь мэдрэлийн тогтолцооны өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

Ахмад настуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах шаардлага дээрх судалгаа нотолгоонд тулгуурлан гарч байна.

Геронтологийн үндэсний төв нь жилд дунджаар нийт настуудын 22 хувьд нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Цаашид өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд үндэслэн ахмад настны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбар дундын оролцоонд тулгуурлан өргөжүүлэх, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний нэр төрөл нэмэгдүүлэх, Олон улсын туршлага, загварыг нэвтрүүлж, нутагшуулах хэрэгцээтэй байна.

Геронтологийн үндэсний төв нь ерөнхий захирлын 2017 оны А/64 дугаар тушаалаар 2017-2020 он хүртэлх байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулан 4 жил хэрэгжүүлэн ажилласан. Геронтологийн үндэсний төвийн 2017-2020 оны стратеги төлөвлөгөөнд 7 стратеги, 29 зорилтын хүрээнд нийт 91 үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн байснаас 83 хувийн хэрэгжилттэй байна.

Геронтологийн үндэсний төвийн 2022-2025 оны хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”, “Ахмад настны тухай хууль”, “Насжилтын асуудлаарх үндэсний стратеги”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын

“Эрүүл насжилтын арван жил 2021-2030” баримт бичиг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал болон бусад холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүд үндэслэл болгон боловсруулсан.

Энэхүү баримт бичиг нь Геронтологийн үндэсний төвийг 2023-2026 онд хөгжүүлэх үндсэн баримт бичиг бөгөөд байгууллагын жил бүрийн төлөвлөгөөний суурь баримт юм.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Геронтологийн үндэсний төвийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын шинжилгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг мөрдлөг болгосон.

Алхам 1. Геронтологийн үндэсний төвийн чиг үүргийг тодорхойлох

Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагаанд хамаарах ерөнхий болон үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахад нийтлэг мөрдөх 10, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 209 дугаар тогтоолоор батлагдсан Геронтологийн төвийн дүрэмд тулгуурлан тодорхойлсон болно. Тус төвийн чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох дүрмийг үзвэл ерөнхий чиг үүрэг 3, үндсэн чиг үүрэг 5 байна. Үүнийг дараах хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 1. Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагаанд нийтлэг мөрдөгдөж байгаа хуулийн тоо

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо	40
Нийтлэг мөрддөг хуулийн тоо 10	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн тухай хууль 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль 3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 5. Төсвийн тухай хууль 6. Авилгын эсрэг хууль 7. Хөдөлмөрийн тухай хууль 8. Ахмад настны тухай хууль 9. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
Бусад холбогдох хуулийн тоо 30	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл ахуйн тухай хууль 2. ХДХВ/ДОХ-той тэмцэх сэргийлэх хууль 3. Дархлаажуулалтын тухай хууль 4. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль 5. Тамхины хяналтын тухай хууль 6. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 7. Нийгмийн халамжийн тухай хууль 8. Зөрчлийн тухай 9. Статистикийн тухай хууль 10. Иргэний хууль 11. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай 12. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай 13. Шинжлэх ухаан технологийн тухай 14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 15. Патентийн тухай 16. Хувь хүний орлогын албан татварын тухай 17. Зар сурталчилгааны тухай 18. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 19. Хог хаягдлын тухай хууль 20. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай 21. Онц байдлын тухай хууль 22. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 23. Гамшгаас хамгаалах тухай 24. Галын аюулгүй байдлын тухай 25. Газрын тухай 26. Залуучуудын хөгжлийн дэмжих тухай 27. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай 28. Органик хүнсний тухай 29. Биений тамир спортын тухай 30. Улсын тэмдэгтийн тухай

Хүснэгт 2. Геронтологийн үндэсний төвийн ерөнхий болон үндсэн чиг үүрэг

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэгч
Нэг. Ерөнхий чиг үүрэг: Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлэх			
1.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох	ЭМЯ, НЭМҮТ, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар, ДЭМБ, Монголын ахмадын холбоо
		Ахмад настны эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг дангаараа болон салбар дундын болон олон нийт, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах	
		Гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх	
1.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг өргөжүүлж хүртээмж нэмэгдүүлэх	ЭМЯ, Дүүрэг, аймгуудын гериатрийн кабинет, Ахмадын сувилалууд
		Ахмад настны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулж, эрсдлийг бууруулах	
		Технологи инновацыг тэгш хүртээмжтэй ашиглах боломжийг бүрдүүлэн, сургаж хөгжүүлэх	
Хоёр. Ерөнхий чиг үүрэг: Үндэсний хэмжээнд ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр ханган, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх			
2.1	Геронтологи, гериатрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх	Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүний нөөцийг үе шаттай төлөвлөж геронтологи, гериатрийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх	Эрүүл мэндийн хөгжлийн төв АШУУИС ДЭМБ
2.2	Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлж нотолгоонд үндэслэн эрүүл насжилтыг дэмжих	Монгол настуудын эрүүл мэнд, нийгэм сэтгэцийн суурь судалгааг өргөжүүлэн, нотолгоонд тулгуурласан Геронтологи, гериатрийн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх	ЭМЯ, АШУУИС, ДЭМБ
Гурав. Ерөнхий чиг үүрэг: Байгууллагын хөгжил, ил тод байдлыг хангах			
3.1	Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалт, ил тод байдлыг хангах	Байгууллагын хөгжил, бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх	ЭМЯ, ЭМДЕГ
		Төвийн санхүүгийн төлөвлөлтийг шинэчлэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх	

Алхам 2. Холбогдогч талуудыг тодорхойлох. Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Геронтологийн үндэсний төвөөс бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв. Тус төвийн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагаанд холбогдогч талууд

№	Холбогдогч талууд	Байгууллагын нэр	Харилцааны чиглэл
1	Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэндийн яам	Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллээр хангах
2	Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, БОЭТ, ӨЭМТ, СЭМТ, ТЭМТ, сувиллын газрууд	Лавлагаа шинжилгээ хийлгэх, Төрөлжсөн мэргэшлийн болон тасралтгүй сургалт зохион байгуулах
3	Төрийн захиргааны байгууллагууд	Нийслэл, дүүргийн харъяа байгууллагууд	Хамтран ажиллах, мэдээлэл солилцох
4	Олон улсын байгууллага	ДЭМБ, АХБ, Жайка, Дезерет,	Хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
5	Сургалт, судалгааны байгууллага	ЭМХТ, АШУУИС, УАУТХ,	Төрөлжсөн мэргэшлийн болон тасралтгүй сургалт зохион байгуулах, чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх
6	Иргэд		Хамтран ажиллах, мэдээллээр хангах
7	Эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч байгууллага	ЭЭХХЗГ, Ханган нийлүүлэгч байгууллагууд	Төвийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх
8	Интернет, цахим үйлчилгээ, програм хангамжтай холбоотой үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж	Мобинет, Ситинет, Санхүүгийн тооцоолох ХХК	Үндсэн үйл ажиллагааны програм хангамжийн хөгжүүлэлт, Интернет үйлчилгээ авах, Фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан мэдээлэл автоматаар хариу өгөх үйлчилгээ үзүүлэх, Утасны автомат хариулагчийн үйлчилгээ үзүүлэх
9	Цахим шилжилт	Үндэсний дата төв	Үндсэн үйл ажиллагааны програм ажиллуулах вертуал серверээр хангах, үйлчилгээ үзүүлэх
10	Гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллага, холбоо, төрийн болон төрийн бус байгууллага	IAGG, Японы геронтологийн үндэсний төв, БНХАУ-ын Хөх хотын ОУ-ын Монгол эмнэлэг	Геронтологи, гериатрийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, сургалт, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, туршлага солилцох
11	Бусад		Ариутгал, халдваргүйтгэл, цахилгаан эрчим хүч, дулаан

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эрүүл, идэвхтэй урт наслалт насжилт – Хүн бүрийн ирээдүй

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол хүний насжилт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар үйлчлүүлэгчдийг дээдэлсэн тогтолцоог бүрдүүлэн хамт олны хөгжил дэвшлийг хангахад оршино.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчин	
<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none">• Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг үндэсний лавлагаа төв• Эмзэг бүлгийн настуудад гэрээр төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээний олон мэргэжлийн багийн үйлчилгээтэй.• Төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг сургалт эрхлэгч байгууллага.• Нийслэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, ахмадын чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаатай.• Олон улсын насжилт судлалын холбооны гишүүн /IAGG/.	<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none">• Үндэсний хэмжээнд лавлагаа төвийн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эмнэлгийн байр хүрэлцээгүй.• Батлагдсан орон тоогоор ажиллах боломжгүй.• Хүний нөөцийн тогтвор суурьшил хангалтгүй• Жилийн төсөв бодит хэрэгцээнд хүрэлцдэггүй.• Монгол улсын хэмжээнд дэвшилтэт технологийн гериатрийн тусламж үйлчилгээнүүд нэвтрээгүй.
Гадаад орчин	
<p>Боломж</p> <ul style="list-style-type: none">• Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, “Монгол улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги” /2010-2030 он/, “Эрүүл мэндийн тухай хууль” “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль”, “Ахмад настны тухай хууль”, “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”, Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрүүл насжилтийн арван жил 2021-2030 суурь нөхцөл байдлын тайлан, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр-ийн хүрээнд “Эрүүл идэвхтэй амьдрах арга хэмжээний төлөвлөгөө” хүрээнд хөгжлийн дунд хугацааны бодлого тодорхойлогдоно.• Ахмад настуудын эрүүл мэндийн хэрэгцээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна.• Төвийн шинэ эмнэлгийн барилга баригдаж байгаа.	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none">• Улсын хэмжээний гериатрийн тусламж үйлчилгээний бүртгэл, мэдээллийн сан байхгүй.• Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2007, 2011, 2012, 2016, 2018 оны “Барилгын ашиглалт, төлөв байдлын тухай” үнэлгээгээр “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” БНБД 22.01.01*2006 дүрмийн /Өрөгт бүтээцэн ханатай барилга/ 3.38 дахь заалтад тавигдах шаардлагыг хангахгүй их эрсдэлтэй үнэлэгдсэн.• Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал зөрчигдөж, халдварт өртөх эрсдэлтэй.• Төвийн шинээр баригдаж буй цогцолбор барилгын явц удаашралтай байна.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго: Салбар дундын оролцоонд тулгуурласан настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай, хүртээмжтэй хүргэхэд оршино.

Зорилт:

Стратегийн зорилт 1:	Ахмад настныг насжилтаас үүдэлтэй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх
Стратегийн зорилт 2:	Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сүлжээ бий болгож, олон нийтийн оролцоог хангах
Стратегийн зорилт 3:	Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх
Стратегийн зорилт 4:	Настны цогц тусламж, үйлчилгээг хөгжүүлэн, нутагшуулах
Стратегийн зорилт 5:	Ахмад настны гэрийн лавлагаа тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх
Стратегийн зорилт 6:	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх
Стратегийн зорилт 7:	Ахмад настны тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх
Стратегийн зорилт 8:	Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах
Стратегийн зорилт 9:	Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн тасралтгүй байдлыг хангаж, нийгмийн баталгааг хангах
Стратегийн зорилт 10:	Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, эрүүл насжилтийг дэмжих
Стратегийн зорилт 11:	Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын оновчтойг тогтолцоог бүрдүүлэх
Стратегийн зорилт 12:	Төвийн санхүүгийн төлөвлөлтийг шинэчлэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

Геронтологийн үндэсний төвийн бүтэц, хүний нөөц (Зураг 1.)


Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2013 оны 226 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна. Геронтологийн үндэсний төв нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба, Стратеги төлөвлөлтийн алба, Эмнэлгийн тусламж үйлчилгээний алба, Эрдэм шинжилгээ, сургалтын алба гэсэн 4 үндсэн алба, нийт 52 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо (Зураг 2.)


Лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээний түвшинд төрөлжсөн мэргэшлийн төв, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн настны кабинетүүдэд настны эмч, настны сувилагч нар ажиллаж байна. Настанд зонхилон тохиолдох эмгэгийн үеийн оношилгоо, эмчилгээ, настны эрүүл мэндийн үнэлгээг хийж байна. Геронтологийн үндэсний төв нь настны кабинетийн болон хувийн хэвшлийн сэргээн засах төв, сувиллын газруудын эмч, сувилагч нарыг мэргэшүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Анхан шатлалын тусламж, үйлчилгээний түвшинд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд жил бүр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Зураг 1. Геронтологийн үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалт /52 орон т000/ 2022 он



Зураг 2. Монгол улсын настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо



ЕС. GERONТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ (2023-2026 ОН)

Геронтологийн үндэсний төв нь 2023-2026 онд Монгол Улсын хэмжээнд настны цогц тусламж үйлчилгээний хөтөлбөрийг шинэчлэн нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн гериатрийн кабинетийн үйл ажиллагааны үлгэрчилсэн загварыг бий болгож үндэсний хэмжээнд нутагшуулна.


Зураглал 1. 2023-2024 онд Эрүүл мэндийн сайдын 2010 оны 182 дугаар тушаалар батлагдсан Настны эрүүл мэндийн үнэлгээний удирдамжид Олон улсад стандарчлагдсан үнэлгээний аргачлалуудыг нэмэлтээр оруулж шинэчлэн боловсруулна.

2025-2026 онд Шинэчлэн боловсруулсан үнэлгээний аргачлалаар настны эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил аргазүйгээр зааварчилгаа өгч, мэргэшсэн настны эмч нараас бүрдсэн настны кабинет, ахмадын сувилал, сэргээн засах төв, идэвхтэй насжилтийн төвүүдэд үе шаттайгаар 21 аймаг, 9 дүүрэгт настны цогц тусламж үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Зураглал 2. 2023-2024 онд Настны нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх олон нийтийн оролцоог хангах, ухуулга нөлөөлөл, эрт илрүүлэг анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулан зохион байгуулна.

2025-2026 онд Насжилтаас үүдэлтэй өвчлөлийг эрт илрүүлэн, чадвар алдалтыг бууруулах, нийгэм хамт олонд тулгуурласан сэргээн засах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл насжилтын талаар мэдлэг дадлага, хандлагыг нэмэгдүүлж амьдралын чанарыг сайжруулна.

Зураглал 1. Настны цогц тусламж үйлчилгээг шинэчлэн нэвтрүүлэх



Зураглал 2. Настны нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх зураглал



Төлөвлөгөөг баталсан:

Эрүүл мэндийн сайд
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө боловсруулсан:

Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал
(албан тушаал)

Тэмдэг



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2026 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2023 он	2024 он	2025 он	2026 он	
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: 1.АХМАД НАСТАНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЗҮҮЛЭХ								
Үндсэн чиг үүрэг: 1.1. Ахмад настанд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх								
Зорилт 1.1.1. Ахмад настныг насжилтаас үүдэлтэй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх	Настанд зориулсан эрүүл мэндийн сургалт, ухуулгыг зохион байгуулна.	Мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан настны эзлэх хувь	Улсын хэмжээнд 2021 онд нийт настнуудын хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын хэмжээнд нийт настнуудын хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын хэмжээнд нийт настнуудын хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын хэмжээнд нийт настнуудын хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын хэмжээнд нийт настнуудын хувь нь мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан байна.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ

	1.1.1.2. Алслагдсан дүүрэг, тосгоны илрүүлэг сэргийлэх үзлэг зохион байгуулна.	Хамрагдсан настны тоо	2021 онд Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны 250 настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.	Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны 500 настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.	Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны 750 настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.	Алслагдсан аймаг, хороо, тосгоны настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.	Алслагдсан аймаг, дүүрэг, хороо, сум тосгоны 1500 настнуудад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ
1.1.1.3. Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулна.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан	Улсын хэмжээнд ахмадын эрүүл мэндийг дэмжих сарыг жил бүр зохион байгуулсан.	Төвөөс 3 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Үндэсний хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан нэгтгэж ЭМЯ-нд хүргэсэн байна.	Төвөөс 3 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Үндэсний хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан нэгтгэж ЭМЯ-нд хүргэсэн байна.	Төвөөс 3 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Үндэсний хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан нэгтгэж ЭМЯ-нд хүргэсэн байна.	Төвөөс 3 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Үндэсний хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан нэгтгэж ЭМЯ-нд хүргэсэн байна.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ	
Зорилт 1.1.2 Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сүлжээ бий болгож, олон нийтийн оролцоог	1.1.2.1. Настны эрүүл мэнд, нийгмийн асуудлаар МАХХ болон бусад настны чиглэлээр үйл ажиллагаа явуулаг байгууллагуудтай хамтран зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан	“Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал” 2 удаагийн цахим уулзалт, хэлэлцүүлэг зохион	2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдсан байна.	2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдсан байна.	2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдсан байна.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ	

хангах	1.1.2.2. Настанд доройтлын сулалгааг хийж, хүнсний дэмжлэгт хамруулна.	Хүнсний дэмжлэгт хамруулсан настны тоо	байгуулсан. Эрүүл насжилт настны эрүүл мэнд хөтөлбөрийн эцсийн дүгнэлтээр үндэсний хэмжээнд хоол тэжээлийн доройтолд орох эрдэлтэй настан 24.2 хувь, хоол тэжээлийн доройтол 3 хувь байна.	100 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна.	250 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна.	500 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна.	1000 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ
	1.1.2.3. Геротологийн төвөөр настнууд насны тархалтыг тогтоож, хүргэх үлдсэн өвчинг эрт илрүүлэг, тогтолцоог бүрдүүлнэ.	Хамрагдсан настны тоо	2020 оны Насны доройтлын тархалтын судалгаа	600 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна.	1000 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна.	1500 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна.	2000 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна.	Улсын төсөв ЭМДС ДЭМБ
	1.1.2.4. Эрүүл насжилтыг нийгмийн хүрээлэн буй орчны эрүүл мэндэд нөлөөлөх бууруулахад хэмжээг төрийн байгууллагуудтай	Хамрагдсан байгууллагуудын тоо	Эрүүл мэндийн байгууллагуудын чанар сайжруулах COPE үнэлгээг эрүүл мэндэд эрт орчин бүрдүүлэх чиглэлээр нийслэлийн 144 ӨЭМТ-г үнэлж зөвлөгөө өгсөн.	40 ААН, 110 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ	50 ААН, 120 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ	60 ААН, 130 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ шалгаруулж урамшуулсан	70 ААН, 140 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ	Улсын төсөв ЭМДС ДЭМБ

	<p>хамтран настан ээлтэй байгууллага орчин бүрдүүлнэ. ЗГҮАМХ 2.1.1.1.</p> <p>1.1.2.5. Доройтолтой настны байршил, эрүүл мэндийн үзүүлэлтийг хамруулсан мэдээллийн санг үүсгэнэ.</p>	<p>Тогтмол баяжилт хийсэн мэдээллийн сан</p>	<p>Байхгүй</p>	<p>ӨЭМТ шалгаруулж урамшуулсан байна.</p>	<p>шалгаруулж урамшуулсан байна.</p>	<p>байна.</p>	<p>шалгаруулж урамшуулсан байна.</p>	<p>Байгууллагын төсөв, төсөлт хөтөлбөр</p>
<p>Зорилт 1.1.3. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтгийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх (ЗГҮАМХ)</p>	<p>1.1.3.1. Эрүүл мэндийн улсын албаны тушаал, шийдвэр, төлөвлөгөөтэй уялдуулан Геронтологийн үндэсний төвийн Тохюоллын удирдлагын тогтолцооны төлөвлөгөөг тогтмол шинэчлэн, бэлэн байдлыг хангаж ажиллана.</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p>	<p>Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар 2 удаагийн тодотгол хийж батлуулсан ТУТ-ны төлөвлөгөөг 95.1 хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Байгууллагын төсөв</p>
<p>1.1.3.2. Коронавируст халдварт (COVID-19) цар тахлын үед болон үүсээд буй шинэ хэвийн нөхцөлд зорилтог бүлгийн настуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэнэ.</p>	<p>Хамрагдсан ахмад настны тоо</p>	<p>Нийслэлийн 7 дүүргийн 6874 настанд 4 улаагийн эргэлтээр настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн.</p>	<p>2400 настанд настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</p>	<p>400 настанд настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Байгууллагын төсөв</p>	<p>ДЭМБ-ын төсөл, хөтөлбөр</p>

1.2.3. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	1.2.3.1. Настны эрүүл мэндийн чиглэлээр хэрэгцээ шаардлагатай стандарт, удирдамж, эмнэлзүйн шаардлагатай зааврыг шинээр боловсруулж, баталгаажуулна.	Батлагдсан заавар, удирдамжийн тоо	2019 онд 5 заавар, 1 стандартыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сэдвэн 2019 оны 517 дугаар тушаалаар баталгаажуулсан	Эмийн эмчилгээ хийж үр дүнг тооцсон байна.	Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна.	эмчлэх нээж ажиллуулсан байна. 1500 настанд эмчилгээ хийсэн байна.	Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна.	ажиллуулсан байна. 500 настанд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	Байгууллагын төсөв, ДЭМБ-ын санхүүжилт
